



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 ¹⁹ он ⁰¹ дугаар
сарын ²⁵ ны өдөр

Дугаар ¹³⁷¹/₂₂₂

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
М.ЭНХБОЛД ТАНАА

Ерөнхий сайдын мэдээллийн тухай

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн нэгдсэн хуралдаанд Эдийн засгийн коридор байгуулах, дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага, ач холбогдол, бэлтгэл ажлын явцын талаар мэдээлэл хийх болсныг үүгээр уламжилж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



 Г.ЗАНДАНШАТАР

0000407

ЭДИЙН ЗАСГИЙН КОРИДОР БАЙГУУЛАХ, ДАМЖИН ӨНГӨРӨХ ТЭЭВРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА, АЧ ХОЛБОГДОЛ, БЭЛТГЭЛ АЖЛЫН ЯВЦЫН ТАЛААР УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ЕРӨНХИЙ САЙД У.ХҮРЭЛСҮХИЙН ХИЙХ МЭДЭЭЛЭЛ

Нэг. Хэрэгцээ, шаардлага

Өргөн уудам нутаг дэвсгэртэй, далайд гарцгүй орны хувьд Монгол Улс Ази, Европ тивийг холбосон хамгийн дөт зам бүхий газар зүйн байршлын давуу талаа ашиглан олон улсын худалдаа, тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээг өргөжүүлж, дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэх нь дэлхийн худалдаа, эдийн засгийн сүлжээнд идэвхтэй оролцох, эдийн засгийн нөхцөл байдлаа сайжруулах, зам, тээврийн салбарын хөгжилд чухал нөлөөтэй юм.

Монгол Улсын Засгийн газрын зүгээс хөрш орнуудтай тээврийн салбарын хоёр болон гурван талт урт хугацааны харилцан ашигтай хэлэлцээрийг байгуулж, экспортын бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд гаргах, далайн боомт хүртэлх тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах, өөрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээврийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд онцгой анхааран ажиллаж байна.

Хоёр. Зорилго, ач холбогдол

Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн зорилго нь Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хооронд худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, бараа бүтээгдэхүүнийг өрсөлдөх чадвараар хангах, хил дамнасан тээврийг хөнгөвчлөх, дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн хамтарсан төслүүдийг хэрэгжүүлэх замаар гурван талт хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх нөхцөлийг хангахад оршино.

Хөтөлбөрийн хүрээнд дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлснээр дараах боломжууд бий болно гэж Монгол Улсын Засгийн газар үзэж байна. Үүнд:

1. Зам, тээврийн салбарын өрсөлдөх чадвар нэмэгдэж, бусад салбарын хөгжлийг хангагч гол тулгуур болон эдийн засгийн өсөлтийг хурдасгана;
2. Монгол Улс Ази, Европ тивийг холбосон олон улсын тээвэр, логистикийн коридорыг үе шаттай хөгжүүлснээр найдвартай, хямд, үр ашигтай тээврийн нэгдсэн сүлжээ бий болж, олон улсын худалдаа, тээвэр, логистикийн зах зээлд өрсөлдөх чадвараа дээшлүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн тухай

Узбекистан Улсын Ташкент хотноо 2016 оны 6 дугаар сарын 23-24-ний өдөр болсон Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын Дээд хэмжээний уулзалтын үеэр зохион байгуулагдсан Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Төрийн тэргүүн нарын гурав дахь удаагийн уулзалтаар талууд "Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр"-т гарын үсэг зурсан.

Хөтөлбөр нь Үндсэн болон Хавсралт хэсгээс бүрдэх бөгөөд Үндсэн хэсэгт хөтөлбөрийн зорилго, хамтын ажиллагааны чиглэл, зарчим, төслүүдийн санхүүжилт, хэрэгжүүлэх механизм зэргийг тусгасан.

Харин Хавсралт хэсэгт гурван тал хамтран хэрэгжүүлэх дэд бүтцийн бүтээн байгуулалт буюу авто замын болон төмөр замын коридорууд, дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэх, аж үйлдвэрийн хамтын ажиллагаа, хил, хянан шалгалтыг хөнгөвчлөх, эрчим хүч, аялал жуулчлал, байгаль орчин, гаалийн хамтын

ажиллагааг эрчимжүүлэх, боловсрол, шинжлэх ухаан, техник, хөдөө аж ахуй, хүмүүнлэгийн болон эрүүл мэндийн хамтын ажиллагааны чиглэлээр нийт 32 төсөл бүхий жагсаалтыг тусгаснаас тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх 13 төсөл байна.

Дөрөв. Хэрэгжүүлж буй үйл ажиллагаа

Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн хүрээнд:

Монгол Улс Хөтөлбөрт гарын үсэг зурснаас хойш холбогдох ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулж ирсэн.

ОХУ-ын Москва хотноо 2017 оны 8 дугаар сарын 29-ний өдөр болсон Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хамтарсан ажлын хэсгийн шинжээчдийн түвшний хоёрдугаар уулзалтаар хамтарсан механизм байгуулах тухай Санамж бичгийг байгуулахаар тохиролцож, улмаар 2018 оны 5 дугаар сард гурван талын шинжээчдийн түвшний видео хурлыг зохион байгуулан яриа хэлэлцээг явуулсны дүнд мөн оны 9 дүгээр сард ОХУ-ын Владивосток хотноо зохиогдсон Дорнын эдийн засгийн форумын үеэр “Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридорыг хамтран урагшлуулах механизм байгуулах тухай Монгол Улсын Гадаад харилцааны яам, ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн яам, БНХАУ-ын Хөгжил, шинэчлэлийн хороо хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-т талууд гарын үсэг зурсан.

Улаанбаатар хотноо 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хамтарсан ажлын хэсгийн шинжээчдийн түвшний ээлжит дөрөвдүгээр хуралдаан амжилттай болж өндөрлөсөн. Уулзалтаар Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа хамтын ажиллагааны өнөөгийн байдлыг дүгнэн ярилцаж, цаашид авах арга хэмжээний талаар тохиролцсон.

Тухайлбал, төмөр замын “Төв” коридорыг үе шаттай шинэчлэн хөгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэлийг судлах хамтарсан ажлын хэсэг байгуулах, Азийн авто замын сүлжээгээр олон улсын авто тээвэр гүйцэтгэх тухай гурван улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг идэвхжүүлэх, Улаанбаатар хотноо гурван талын Хөрөнгө оруулалтын зураг төслийн төв байгуулах ажлыг эрчимжүүлэхээр тохиролцов.

Түүнчлэн төмөр замын “Хойд” коридорын Эрдэнэт-Овоот чиглэлийн төслийг хэрэгжүүлэх, Азийн авто замын сүлжээний АН-3 чиглэлийн дамжин өнгөрүүлэх чадавхыг нэмэгдүүлэх, эрчим хүчний салбарт хамтарсан төсөл хэрэгжүүлэх боломжийн талаар санал солилцсон болно. Уулзалтын үеэр хүрсэн тохиролцоог хэрэгжүүлэхэд талууд анхаарч ажиллан, үр дүнг 2019 оны эхний хагас жилд зохион байгуулах гурван талын хамтарсан ажлын хэсгийн дарга нарын уулзалтын үеэр хэлэлцэхээр тогтсон.

Зөвлөлдөх уулзалтын дүнгээр дараах заалтууд бүхий протокол үйлдэж, гарын үсэг зурсан. Үүнд:

1. Төмөр замын “Төв” коридорын нэвтрүүлэх чадварыг тээврийн хэмжээний өнөөгийн болон хэтийн төлвийн өсөлтөд нийцүүлэн нэмэгдүүлэх шаардлагатай гэдэгт талууд санал нэгдэж, уг коридорыг шат дараатай хөгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэлийг бэлтгэх, зохион байгуулах зорилгоор хамтарсан ажлын хэсэг байгуулах;
2. Талууд Монгол Улсын нутаг дэвсгэр дэх Азийн авто замын сүлжээний АН-3 маршрутын дамжин өнгөрүүлэх чадварыг нэмэгдүүлэх боломжийг судлах;

3. Азийн авто замын сүлжээгээр олон улсын авто тээвэр гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг улсуудын эрх бүхий төрийн байгууллагуудтай хамтран урагшлуулахаар тус тус тохиролцсон.

Мөн талууд хамтын ажиллагааны хүрээнд эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн дэд бүтцийн төсөл, хөтөлбөрүүд амжилттай хэрэгжиж байгааг цохон тэмдэглэсэн.

Протоколд тусгагдсан заалтуудыг хэрэгжүүлэх хүрээнд 2019 оны 1 дүгээр улиралд ОХУ, БНХАУ-ын Тээврийн яам болон бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллахаар төлөвлөж байна.

Төмөр замын тээврийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр:

Төмөр замын “Төв” коридорыг шинэчлэн хөгжүүлэх, хос зам барих, цахилгаанжуулах эдийн засгийн үндэслэлийг судлах, үндэслэлтэй тохиолдолд хэрэгжүүлж эхлэхээр заасан байдаг.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж байгаагаас гадна ОХУ-БНХАУ, Европ-БНХАУ-ын хоорондын гадаад худалдааны хэмжээ нэмэгдэж, дамжин өнгөрөх тээврийн хэмжээ нэмэгдэх таатай нөхцөлийг бүрдүүлж байгаа нь төмөр замын тээх, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагыг бий болгож байна. Төмөр замын дамжин өнгөрөх тээвэр нь өөрийн өртөг бага хэдий ч ихээхэн хэмжээний орлого олдог, төмөр замын тээврийн хамгийн ашигтай төрөл тул манай улс нь газар зүйн байршлын давуу талаа ашиглан дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлснээр их хэмжээний валютын орлого олох боломжтой.

2017 онд төмөр замын “Төв” коридорын Сүхбаатар-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн төмөр замаар нийт 3.1 сая тонн дамжин өнгөрөх ачаа тээвэрлэсэн нь 2016 онтой харьцуулахад 30.8 хувиар өссөн байна. Үүний дотор Монгол Улсын нутгаар дамжин БНХАУ-аас Европын болон эсрэг чиглэлд явдаг чингэлгийн буухиа галт тэрэгний хэмжээ огцом нэмэгдэж байгаа бөгөөд 2016 онд 167, 2017 онд 556 чингэлгийн буухиа галт тэрэг тус тус дамжин өнгөрсөн бол 2018 оны эхний 11 сарын байдлаар 778 буухиа галт тэрэг дамжин өнгөрөөд байна.

Дамжин өнгөрөх тээвэр нь “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн нийт ачаа тээврийн 13.6 хувийг эзэлж байгаа ч тээврийн орлогын 30.3 хувийг бүрдүүлж байна. Одоогийн байдлаар ОХУ болон БНХАУ-ыг холбосон гол төмөр замын нийт урт 1110 км бөгөөд суурь бүтцийн хүчин чадал нь жилд 22-25 сая тонн ачаа тээвэрлэх боломжтой байна.

Цаашид төмөр замаар тээвэрлэгдэх ачааны хэмжээ улам нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд “Улаанбаатар төмөр зам” ХНН-т 2018 онд 29 сая тонн ачаа тээвэрлэх захиалга ирсэн нь техникийн хувьд эрэлт хэрэгцээг хангахад хүндрэл үүсэх эрсдэлтэй байгаа хэдий ч өөрийн нөөц бололцоонд тулгуурлан замын их засвар, хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх ажлыг хэрэгжүүлж байна.

Эдгээр төслүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар төмөр замын шинэчлэлийн төслийг төмөр замын “Хойд” чиглэлийн Эрдэнэт-Овоот, “Шинэ төмөр зам” төслийн Тавантолгой-Сайншанд-Хөөт-Чойбалсан болон Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төслүүдтэй уялдуулах чиглэлээр зорилт тавин ажиллаж байна.

Төмөр замын “Зүүн” коридор нь Ази-Европыг холбосон хамгийн ачаалалтай коридор болох Забайкальск-Манжуурын коридортой өрсөлдөж ачаа урсгалын тодорхой хувийг татах, зүүн хойд Хятадын бүс нутгийг 300 орчим км дөт замаар Орос, Европтой холбох, Монгол Улс зүүн хойд Хятадын далайн боомтуудыг ашиглан хамгийн дөт замаар далайд гарах боломжийг бүрдүүлэх юм.

Төмөр замын “Хойд” коридорыг байгуулж “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн шугамтай холбосноор Овоотын нүүрсний уурхайгаас төдийгүй ОХУ-ын Тувагийн бүс нутгийн их хэмжээний нүүрсийг зах зээлийн эргэлтэд оруулах, гуравдагч зах зээл рүү дамжуулан тээвэрлэх боломж бүрдэх бөгөөд “Төв” коридорын ачаа тээврийн хэмжээ нэмэгдэж, эдийн засгийн үр ашиг дээшлэх юм.

“Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлийн концессоор хэрэгжиж байгаа Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын төслийн олон улсын банк, санхүүгийн байгууллагын шаардлага хангасан техник, эдийн засгийн үндэслэлийг бүрэн боловсруулж, 2018 оны 10 дугаар сард хүлээн авсан.

Төмөр замын “Төв” коридорын ачааллыг багасгах, Замын-Үүд-Эрээн төмөр замын хилийн боомтын урсгалын тодорхой хэсгийг хөнгөвчлөх зорилгоор Зүүнбаян-Ханги чиглэлийг хөгжүүлэх зайлшгүй шаардлага үүсч байна.

Төмөр замын дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэх чиглэлээр:

Улаанбаатар хотноо 2018 оны 6 дугаар сард зохион байгуулагдсан “Монгол, Орос санаачилга-2018” арга хэмжээний үеэр Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайд, ОХУ-ын Тээврийн сайд нар “Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцөлийн тухай Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т үсэг зурсан. Энэхүү хэлэлцээрийн хүрээнд:

- Хоёр улсын нутаг дэвсгэрийн төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрт тарифын уян хатан бодлого хэрэгжүүлэх;
- Төмөр замын ачаа тээвэрт бусад чиглэлүүдтэй харьцуулахад өрсөлдөхүйц тарифын нөхцөлийг урт хугацаанд хангах;
- Төмөр замаар тээвэрлэж байгаа ачааг улсын хилээр нэвтрүүлэх ажиллагааг хөнгөвчлөх нөхцөлийг бүрдүүлэх;
- Хоёр улсын төмөр замын ачаа тээврийн өсөлтийг дэмжих;
- Ачаа тээврийн өсөлтийн эрчим болон төмөр замын тээврийн суурь бүтцийн хөгжил, харилцан уялдааг хангах;
- Монгол Улсын экспортлогчдод далайд саадгүй гарах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг хоёр улсын стратегийн түншлэлийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой заалтуудыг тусгасан.

Уг хэлэлцээрийн хүрээнд манай улсын экспортын бараа, бүтээгдэхүүнийг ОХУ-ын нутаг дэвсгэрээр дамжуулан гуравдагч зах зээлд гаргахад төмөр замын тарифын хөнгөлөлтийг 25 жилийн турш эдлэх юм.

БНХАУ-ын “Бүс ба зам” санаачилгын хүрээнд хуурай газрын тээврийн коридоруудыг хөгжүүлж, бараа эргэлтийг хурдасгах бодлого баримтлан, БНХАУ-аас Европын чиглэлд тээвэрлэх ачааг далайн тээврээс чингэлэг тээвэрт аажмаар шилжүүлж байгаа бөгөөд өнгөрсөн онд чингэлэг тээврийн нийт 3600 буухиа галт тэрэг Европын чиглэлд аялсан бол 2020 онд 5000 буухиа галт тэрэгт хүргэх зорилт дэвшүүлсэн байна. Монголын тал дамжин өнгөрөх тээврийн тариф, шилжүүлэн ачилтын тарифт хөнгөлөлт үзүүлэх, хил нэвтрэлтийг хөнгөвчилж, технологит хугацааг багасгах зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлсний дүнд Монгол Улсын нутгаар

2017 онд 556 буухиа галт тэрэг дамжин өнгөрсөн нь 2016 оноос 3 дахин өссөн үзүүлэлт юм.

2014 онд БНХАУ-ын дарга Си Зиньпин Монгол Улсад төрийн айлчлал хийх үеэр "Төмөр замын дамжин өнгөрөх тээврийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т гарын үсэг зурсан. Мөн шинэчлэн байгуулсан "Монгол Улс БНХАУ-ын нутгаар дамжин далайд гарах, буцах, дамжин өнгөрөх тээвэр хийх тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн дагуу БНХАУ-ын хойд, зүүн хойд бүс нутгийн Тяньжин, Дандун, Далиен, Чинхуандао, Хуанхуа, Жинжоу, Инкоу зэрэг 7 далайн боомтыг ашиглан далайд гарах эрх албан ёсоор нээгдсэн болно.

Төмөр замын дамжин өнгөрөх тээврийг нэмэгдүүлэх зорилгоор 2017 оны 4 дүгээр сард БНХАУ-ын Бээжин хотноо "Транзит Монгол-2017", 2018 оны 4 дүгээр сард ОХУ-ын Москва хотноо "Транзит Монгол-2018" олон улсын чуулга уулзалтыг тус тус зохион байгуулсан. Чуулга уулзалтад оролцогч БНХАУ, ОХУ, Литва, Польш, Герман зэрэг орнуудын төрийн байгууллага, төмөр зам, томоохон ачаа илгээгч, хүлээн авагчдад Монгол Улсын төмөр замын дамжин өнгөрөх тээврийг нэмэгдүүлэх талаар баримталж буй бодлого, дамжин өнгөрөх тээврийн тарифын уян хатан бодлого, шилжүүлэн ачих үйл ажиллагааны үнийн хөнгөлөлтийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар танилцуулсан болно.

Автотээврийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр:

ОХУ-ын Москва хотноо 2016 оны 12 дугаар сарын 8-9-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (АНДЭЗНК)-ийн Тээврийн сайд нарын бага хурлын үеэр Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Засгийн газрын төлөөлөл "Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай хэлэлцээр"-т гарын үсэг зурж, улмаар 2018 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хурлаар соёрхон батлуулсан.

Энэхүү хэлэлцээрийг байгуулах бэлтгэл ажлын хүрээнд гурван улс туршилтын тээвэрлэлтийг Азийн авто замын сүлжээний АН-3 Тяньжин-Улаанбаатар-Улаан-Үдийн чиглэлд 2016 оны 8 дугаар сарын 13-26-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулсан.

Уг хэлэлцээр нь Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний хүрээнд байгуулсан анхны баримт бичиг бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээвэрлэлтийг хөгжүүлэхэд онцгой ач холбогдолтой юм.

"Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай хэлэлцээр"-ийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд авто замын нөхцөлийг сайжруулах, хил, гаалийн үзлэгийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, Замын-Үүд, Булган, Цагааннуур, Алтанбулаг боомтын дэд бүтцийг хөгжүүлэх, цагийн хуваарьт өөрчлөлт оруулах зэрэг ажлыг хангах шаардлагатай байгаа тул ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

Улаанбаатар хотноо 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр НҮБ-ын АНДЭЗНК-ийн дэмжлэгтэйгээр уг хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах Ажлын хэсгийн хурлыг зохион байгуулсан. Уулзалтад АНДНЭЗК, Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын эрх бүхий байгууллагын төлөөллүүд оролцож, уулзалтын үр дүнд гарсан баримт бичигт дараах зүйлсийг тогтсон болно. Үүнд:

- Хэлэлцээр 2018 оны 9 дүгээр сарын 21-ний өдрөөр хүчин төгөлдөр болох;

- Хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах Хамтарсан хороог АНДЭЗНК-ийн дэргэд байгуулах саналыг хэлэлцэх
- Талууд 2019 онд шаардагдах автотээврийн зөвшөөрлийн урьдчилсан тооны талаар мэдээлэл солилцох;
- Хятадын тал Хамтарсан хороог Тээврийн яамдын дэд сайд нараар ахлуулах санал дэвшүүлснийг Монгол болон Оросын тал дипломат шугамаар мэдээлэх зэрэг болно.

Унгар Улсын Будапешт хотноо 2018 оны 11 дүгээр сарын 20-21-ний өдрүүдэд болсон Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол-Унгарын Засгийн газар хоорондын комиссын ээлжит зургаадугаар хуралдааны үеэр “Автотээврээр олон улсын ачаа болон зорчигч тээвэрлэх тухай Монгол Улс, Унгар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т гарын үсэг зурсан.

Түүнчлэн дамжин өнгөрөх тээвэрлэлтийг хөгжүүлэх зорилгоор Польш, Чех, Герман, Словак, Итали зэрэг Европын орнуудтай автотээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулахаар ажиллаж байна.

Авто замын салбарыг хөгжүүлэх чиглэлээр:

Монгол Улсын баруун бүс нутгаар дайран өнгөрдөг Азийн авто замын сүлжээний АН-4 чиглэл буюу Новосибирк-Барнаул-Горно Алтайск-Ташанта-Улаанбайшинт-Ховд-Ярант-Такешен-Өрөмч-Каши-Хонкираф чиглэлийн авто замыг дамжин өнгөрөх тээвэрлэлтэд идэвхтэй ашиглах зорилтыг тавьсан.

Тус чиглэлийн авто замын сүлжээ нь Монгол Улсын нутаг дэвсгэрээр нийт 756 км авто замыг дайран өнгөрдөг. Монгол Улсын Засгийн газраас энэхүү авто замын сүлжээг хөгжүүлэхэд анхаарч улсын төсөв, Азийн хөгжлийн банкны зээл, тусламж, БНХАУ-ын ЭКСИМ банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр үе шаттайгаар барьж байгуулан, нийт сүлжээний 506.3 км буюу 70 орчим хувийг ашиглалтад оруулаад байна. Одоо үлдэж байгаа авто замын 60 км авто замыг Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар, 189.7 км авто замыг Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар тус тус хэрэгжүүлж байгаа бөгөөд 2019 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Авто замын сүлжээний дагуу олон улсын жишигт нийцсэн замын хажуугийн байгууламж барьж байгуулах (тэмдэг, тэмдэглэгээ, төлбөр хураах цэг, үйлчилгээний цогцолбор зэрэг) ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Азийн авто замын сүлжээний АН-3 буюу Улаан Үүд-Хиагт-Алтанбулаг-Дархан-Улаанбаатар-Сайншанд-Замын-Үүд-Эрээн-Бээжин-Тяньжин чиглэлийн авто замыг дамжин өнгөрөх тээвэрлэлтэд идэвхтэй ашиглах зорилтыг тавьсан. Тус чиглэлийн авто зам нь Монгол Улсын нутаг дэвсгэрээр нийт 990 орчим км дайран өнгөрдөг.

Авто замын сүлжээ бүхэлдээ хатуу хучилттай авто замаар холбогдсон хэдий ч үр ашигтай дамжин өнгөрөх тээвэрлэлтийг хангахад өргөтгөл, шинэчлэл хийх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Аливаа тээврийн коридор нь аль улсын нутаг дэвсгэрт байгаагаас үл хамаарч бүхэлдээ сайн чанарын аюул осолгүй, найдвартай, үр ашигтай авто замын дэд бүтэцтэй байх шаардлагатай.

Хөрш хоёр орны эдийн засгийн коридорт хамрагдаж байгаа авто замын сүлжээний ашиглалтын байдлыг авч үзэхэд БНХАУ-ын авто замын сүлжээ нь бүхэлдээ Азийн авто замын сүлжээний ангиллаар 1 дүгээр зэргийн, ОХУ-ын авто замын сүлжээ нь Азийн авто замын сүлжээний ангиллаар 2 дугаар зэрэгт хамаарч байгаа бол манай авто замын коридор нь 3 дугаар зэрэгт, зарим хэсэгтээ үүнээс доогуур ангилалд хамаарахаар байна.

Азийн авто замын АН-3 дугаартай, олон улс, улсын чанартай А01 дугаартай Улаанбаатар-Чойр-Сайншанд-Замын-Үүд чиглэлийн 661.9 км хатуу хучилттай авто замын А0101 дугаартай Улаанбаатар-Чойр чиглэлийн 224.5 км хатуу хучилттай авто зам нь 2003-2005 онд баригдсан. Хэдийгээр өдөр тутмын арчлалтын ажил жил бүр хийгдэж ирсэн боловч ээлжит болон их засвар шинэчлэлтийн ажлыг сайтар хийгээгүйн улмаас авто замын нөхцөл байдал ихээр муудсан.

Харин А0102 дугаартай Чойр-Сайншанд чиглэлийн 221.4 км хатуу хучилттай авто зам нь 2006-2013 онд баригдаж, түүнээс хойш арчлалтын ажил жил бүр тогтмол хийгдэж ирсэн бөгөөд авто замын нөхцөл байдал хэвийн байна.

А0103 дугаартай Сайншанд-Замын-Үүд чиглэлийн 216 км хатуу хучилттай авто зам нь 2003-2013 онд баригдсан бөгөөд түүнээс хойш арчлалтын ажил жил бүр тогтмол хийгдэж ирсэн хэдий ч тус замын Замын-Үүд талын 60 км-т авто замын зорчих хэсгийн чиглэлд хүнд даацын авто машин ихээр зорчсоноос шалтгаалан эвдрэл үүсч, засварлах шаардлагатай болоод байна.

Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замд өргөтгөл, шинэчлэл хийх ажлыг БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсний дагуу төслийн гүйцэтгэгч болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгчтэй гэрээ байгуулан ажиллаж байна.

Авто замын "Зүүн" коридорын хувьд Борзя-Соловьевск-Эрзэнцав-Чойбалсан-Баруун-Урт-Бичигт-Зүүнхатавч-Си-Уджимчин-Ци-Улаанхад/ Шилийн хот-Чаоян/Чэндэ-Жиньжоу/Паньзинь/Тяньжин чиглэлийг хөгжүүлэх холбогдох судалгааг хийж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Тус сүлжээ нь Монгол Улсын нутаг дэвсгэрээр нийт 700 орчим км орчим авто замыг дайран өнгөрөх юм. Тус коридорын Баруун Урт-Бичигт чиглэлийн 272 км авто зам нь 2017 онд Азийн авто замын сүлжээний АН35 Өндөрхаан-Баруун Урт-Бичигт-Жинжоу чиглэлийн сүлжээнд хамрагдсан. Азийн авто замын сүлжээний АН35 сүлжээ нь Монгол Улсын БНХАУ-тай хийх худалдаа, эргэлт, түүнчлэн далайд гарах гарцыг нэмэгдүүлэх зэрэг чухал ач холбогдол бүхий коридор юм.

Гурван улсын эдийн засгийн коридорт хамрагдаж байгаа тус сүлжээний Баруун Урт-Бичигт чиглэлийн 272 км авто замын зураг төсөл боловсруулагдсан бөгөөд коридорын бусад хэсэгт авто замын сүлжээг хөгжүүлэх холбогдох судалгааны ажлыг яаралтай эхлүүлэх шаардлагатай байна.

Хуурай боомтыг хөгжүүлэх чиглэлээр:

Монгол Улс 2013 оны 11 дүгээр сард Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурж, улмаар Улсын Их Хурал 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр соёрхон баталсан. Уг хэлэлцээрт Алтанбулаг, Улаанбаатар, Сайншанд болон Замын-Үүдийг хуурай боомт, мөн Чойбалсанг хуурай боомт болгох боломжтой талаар тусгасан.

Энэ хүрээнд Ерөнхий сайдын 2018 оны 104 дүгээр захирамжаар Монгол Улсад олон улсын хуурай боомт байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын асуудлыг судалж санал боловсруулах, гадаад улс, олон улсын байгууллагын дэмжлэг авч, төр-хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааг хангах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Тав. Тулгамдаж буй асуудал

1. Монгол, Орос, Хятад гурван улсын нэгдэн орсон "Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай хэлэлцээр"-ийн дагуу тээвэрлэлтийн үйл ажиллагааг эхлүүлэхэд чанарын шаардлага хангасан аюул осолгүй, найдвартай, тав тухтай, авто замын дэд бүтэцтэй байх шаардлага үүсч байна.

2. Манай авто замын коридор нь 3 дугаар зэргийн, зарим хэсэгтээ 3 дугаар зэрэгт ч хүрэхгүй, эвдрэл гэмтэл ихтэй байгаа нь үр ашигтай тээвэрлэлт явуулахад сөргөөр нөлөөлж байна. Иймд Монгол Улсын хувьд авто замын сүлжээний ашиглалтын байдлыг шинэчлэн сайжруулах, хөрш орны жишигт хүргэхэд анхаарах шаардлагатай байна.

3. Авто замын "Зүүн" коридорын Эрэнцав-Чойбалсан-Баруун-Урт-Бичигт чиглэлийн авто замын сүлжээ нь нийт 697 км урт бөгөөд тус чиглэлийн авто замын Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км замын зураг төсөл боловсруулагдаж, төр-хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр хэрэгжүүлэхээр тусгасан. Үлдэж буй авто замын сүлжээний хэсэгт холбогдох судалгаа, зураг төсөл боловсруулах ажлыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4. "Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр"-ийн төмөр замын "Төв", "Зүүн" болон "Хойд" чиглэлийн зарим хэсэг болон Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төслүүдийн техник-эдийн засгийн судалгааг хийж, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхэд шаардлагатай байгаа санхүүжилтийн эх үүсвэр тулгамдаж буй гол асуудлын нэг болж байна.

Шаардлагатай санхүүжилтийг авч үзвэл:

- Төмөр замын "Төв" коридорын "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн техникийн шинэчлэлийн хөтөлбөр /195 км их засварын ажил, 24 зүтгүүр шинээр авах/ - 275.3 сая ам.доллар;
- Төмөр замын "Хойд" коридорын Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын төсөл - 2.2 тэрбум ам.доллар (ТЭЗҮ);
- Төмөр замын "Хойд" коридорын Овоот-Арцсуурь чиглэлийн төмөр замын төсөл - 735 сая ам.доллар;
- Төмөр замын "Зүүн" коридорын Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төсөл - 1.25 тэрбум ам.доллар;
- Төмөр замын "Зүүн" коридорын Чойбалсан-Хөөт чиглэлийн төмөр замын төсөл - 900 сая ам.доллар;
- Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төсөл - 1.1 тэрбум ам.доллар.

5. Монгол Улсын дотоодын эрх зүйн хүрээнд дамжин өнгөрөх тээвэрлэлтийг зохицуулах, зохион байгуулах, хяналт тавих зохицуулалт хангалтгүй байгаа тул эрх зүйн орчныг бүрдүүлэх, сайжруулахад анхаарч ажиллах шаардлагатай байна.